



МОНГОЛБАНК

ШИНЖЭЭЧДИЙН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТАЛААРХ ТӨСӨӨЛӨЛ

2022 ОНЫ III УЛИРЛЫН ТАЙЛАН

Энэхүү тайланд зөвхөн түүвэр судалгаанд хамрагдсан банкууд болон шинжээчдийн эдийн засгийн төлөв байдлын талаарх хүлээлтийн үр дүнг нэгтгэн тайлагнасан учир Монголбанкны албан ёсны байр суурь биш болно.

ШИНЖЭЭЧДИЙН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТАЛААРХ ТӨСӨӨЛӨЛ

Шинжээчдийн макро эдийн засгийн төсөөллийн судалгааг 2022 оны 8 сарын 18-24-ний өдрийн хооронд банкуудын эдийн засагчид, их дээд сургуулиудын багш нар болон судалгааны байгууллагуудын нийт 17 судлаачид (цаашид шинжээч)-ын дунд явуулж, судалгааны үр дүнг нэгтгэн танилцуулж байна.

ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ТОВЧ ҮР ДҮН

Шинжээчид:

2022 оны III улиралд

- Инфляц өнөөгийн түвшнээс бага зэрэг буурч 15.4%,
- Төв банкны бодлогын хүү бага зэрэг өсөж 10.6%,
- Хадгаламжийн хүү бага зэрэг өсөж 8.5%,
- Зээлийн хүү бага зэрэг өсөж 14.7%,
- Мөнгөний нийлүүлэлтийн хувьд өөрчлөлтгүй,
- Зээлийн жилийн өсөлтийг буурч 18.4%,
- Эдийн засгийн өсөлт өнөөгийн түвшинд 1.8%,
- Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийг суларч 3,205.9 төгрөг болно гэж таамагласан байна.

2023 оны II улиралд


- Инфляц буурч 13.9%,
- Төв банкны бодлогын хүү бага зэрэг өсөж 10.7%,
- Хадгаламжийн хүү өсөж 9.3%,
- Зээлийн хүү өсөж 15.3%,
- Мөнгөний нийлүүлэлт өсөж 2.2%,
- Зээлийн жилийн өсөлтийг өнөөгийн түвшнөөс нэлээд буурч 14.5%,
- Эдийн засгийн өсөлтийг өнөөгийгхөөс нэмэгдэж 3.8%,
- Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийг нэлээд суларч 3,332.6 төгрөг болно гэж таамагласан байна.

Огноо	2022 он 7 сар	2022 он III улирал	2022 оны эцэс	2023 он II улирал
Инфляц /ХҮИ-ийн жилийн өсөлт, УБ хот, %/	15.9%	15.4%	15.0%	13.9%
Төв банкны бодлогын хүү /%/	10.0%	10.6%	10.7%	10.7%
Шинээр татсан хадгаламжийн дундаж хүү, /төгрөг, %/	8.3%	8.5%	8.8%	9.3%
Олгосон зээлийн дундаж хүү, /төгрөг, %/	14.3%	14.7%	15.0%	15.3%
M2 мөнгөний өсөлт /жилийн өсөлт, %/	-1.4%	-1.4%	-1.4%	2.2%
Хадгаламжийн байгууллагын зээлийн өсөлт /жилийн өсөлт, %/	20.0%	18.4%	16.4%	14.5%
Эдийн засгийн өсөлт /Бодит ДНБ-ий жилийн өсөлт, %/	1.9%	1.8%	2.5%	3.8%
Валютын ханш /Төгрөгийн ам.доллартай харьцах ханш, хугацааны эцэст/	3,168.1₮	3,205.9₮	3,262.7₮	3,332.6₮

1. Инфляцын таамаглал


Шинжээчид инфляцыг 2022 оны III улиралд дунджаар 15.4%, хамгийн ихдээ 16.9%, хамгийн багадаа 13.5% байхаар төсөөлсөн байна. Цаашид инфляц буурч 2023 оны II улиралд 13.9% байна гэж таамагласан байна (Зураг 1).

Зураг 1 | Инфляц /таамаглал, жилийн хувиар/



Инфляцын таамаглалын хариултыг тархалтаар нь авч үзвэл шинжээчдийн дийлэнх нь 2022 оны III улиралд инфляцын түвшин 14.6%-16.5% байна гэж хариулжээ (Зураг 2).


Зураг 2 | Инфляцын таамаглалын тархалт /2022.III улирал, хариултын тоогоор/



2. Бодлогын хүү


Шинжээчид төв банкны бодлогын хүүг 2022 оны III улиралд дунджаар 10.6%, хамгийн ихдээ 12.0%, хамгийн багадаа 10.0% байна гэсэн хүлээлттэй байна. Цаашид 1 жилийн турш харьцангуй тогтвортой байж 2023 оны II улиралд 10.7% байна гэж таамагласан байна (Зураг 3).

Зураг 3 | Бодлогын хүү /таамаглал, хувиар/



Бодлогын хүүний таамаглалыг тархалтаар нь авч үзвэл шинжээчдийн дийлэнх нь 2022 оны III улиралд бодлогын хүү 10.0% байна гэсэн таамаглалтай байна (Зураг 4).


Зураг 4 | Бодлогын хүүний таамаглалын тархалт /2022.III улирал, хариултын тоогоор/



3. Хадгаламжийн хүү


Шинжээчид шинээр татах төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүүг 2022 оны III улиралд дунджаар 8.5%, хамгийн ихдээ 9.0%, хамгийн багадаа 8.1%-тай байна гэж хариулжээ. Цаашид хадгаламжийн хүү нэмэгдэж 2023 оны II улиралд 9.3% орчим байхаар таамагласан байна (Зураг 5).

Зураг 5 | Хадгаламжийн хүү /таамаглал, жилийн хувиар/



Хадгаламжийн хүүний төсөөллийн тархалтаас харахад шинжээчдийн дийлэнх нь 2022 оны III улиралд хадгаламжийн хүү 8.2%-8.6% байна гэж үзжээ (Зураг 6).


Зураг 6 | Хадгаламжийн хүүний таамаглалын тархалт /2022. III улирал, хариултын тоогоор/



4. Зээлийн хүү


Шинжээчид төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүүг 2022 оны III улиралд дунджаар 14.7%, хамгийн ихдээ 15.5%, хамгийн багадаа 13.9%-тай байна гэжээ. Цаашид зээлийн хүү бага зэрэг нэмэгдэж 2023 оны II улиралд 15.3% орчим байхаар таамагласан байна (Зураг 7).

Зураг 7 | Зээлийн хүү /таамаглал, жилийн хувиар/



Зээлийн хүүний таамаглалын тархалтаас харвал 2022 оны III улиралд зээлийн жигнэсэн дундаж хүүг 14.5%-14.9% байна гэсэн таамаглал давамгайлж байна (Зураг 8).


Зураг 8 | Зээлийн хүүний таамаглалын тархалт /2022. III улирал, хариултын тоогоор/



5. Мөнгөний нийлүүлэлт


Шинжээчид M2 мөнгөний жилийн өсөлт 2022 оны III улиралд дунджаар -1.4%-тай байна гэж үзжээ. Шинжээчид мөнгөний нийлүүлэлтийн өсөлт ирэх улиралд хамгийн ихдээ 2.6%, хамгийн багадаа -5.0%-тай байна гэж таамаглажээ. Цаашид мөнгөний нийлүүлэлтийн өсөлт нэмэгдэж 2023 оны II улиралд дунджаар 2.2% болох таамаглалтай байна (Зураг 9).

Зураг 9 | M2 мөнгөний өсөлт /таамаглал, жилийн хувиар/



Шинжээчдийн таамаглалаас харахад 2022 оны III улиралд мөнгөний нийлүүлэлт -1.9%-иас 1.0%-ийн хооронд байна гэсэн таамаглал давамгайлж байна (Зураг 10).

Зураг 10 | M2 мөнгөний өсөлтийн таамаглалын тархалт /2022.III улирал, хариултын тоогоор/



6. Нийт зээлийн үлдэгдлийн өсөлт


Шинжээчид 2022 оны III улиралд нийт зээлийн жилийн өсөлт дунджаар 18.4%-тай байхаар таамаглаж байна. Үүнээс хамгийн ихдээ 28.5%-д хүрнэ гэсэн бол хамгийн багадаа 12.7%-тай байна гэж үзжээ. Цаашид зээлийн өсөлт бага зэрэг буурч 2023 оны II улиралд 14.5%-д хүрэхээр төсөөлсөн байна (Зураг 11).

Зураг 11 | Зээлийн үлдэгдлийн өсөлт /таамаглал, жилийн хувиар/



Нийт зээлийн жилийн өсөлтийн таамаглалыг тархалтаар нь авч үзвэл шинжээчдийн дийлэнх нь 2022 оны III улиралд 17.8%-иас 22.7%-ийн хооронд байна гэсэн таамаглалтай байна (Зураг 12).


Зураг 12 | Зээлийн үлдэгдлийн өсөлтийн таамаглалын тархалт /2022.III улирал, хариултын тоогоор /



7. Эдийн засгийн өсөлт


Шинжээчид бодит ДНБ-ий өсөлтийг 2022 оны III улиралд дунджаар 1.8%, хамгийн ихдээ 4.2%, хамгийн багадаа -1.4%-тай байхаар төсөөлж байна. Цаашид эдийн засгийн өсөлт нэмэгдэн 2023 оны II улиралд 3.8%-д хүрнэ гэж таамагласан байна (Зураг 13).

Зураг 13 | Бодит ДНБ-ий өсөлт /таамаглал, жилийн хувиар/



Шинжээчдийн таамаглалын давтамжийг тархалтаар нь авч үзвэл 2022 оны III улиралд бодит ДНБ-ий өсөлт 0.7%-иас 4.6%-ийн хооронд байна гэсэн таамаглал давамгайлж байна (Зураг 14).

Зураг 14 | Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглалын тархалт /2022. III улирал, хариултын тоогоор/



8. Валютын ханш

Шинжээчид 2022 оны III улиралд төгрөгийн ам.доллартай харьцах ханш суларч дунджаар 3,205.9 төгрөг, хамгийн ихдээ 3,250.4 төгрөг, хамгийн багадаа 3,109.0 төгрөг байна гэж үзжээ. Цаашид төгрөгийн ханшийн сулралт үргэлжилж 2023 оны II улиралд 3,332.6 төгрөгт хүрнэ гэж таамаглажээ (Зураг 15).

Зураг 15 | Ханш /таамаглал/



Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн таамаглалыг тархалтаар нь авч үзвэл шинжээчдийн дийлэнх нь ханш 2022 оны III улиралд 3,184.1-3,209.0 төгрөг байна гэж хариулжээ (Зураг 16).

Зураг 16 | Ханшийн таамаглалын тархалт /2022. III улирал, хариултын тоогоор/

